



Э.УНДРАХ

Сүхбаатар аймгийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэх албаны
шийдвэр гүйцэтгэгч

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫН АСУУДАЛ

Монгол улсын гэр бүлийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гэр бүлийн эрх зүйн харилцааны тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Тэдгээрийн дотроос нилээд бэрхшээлтэй боловч, зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудал нь хүүхдийн эрх ашиг сонирхол, эрхийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох явдал юм.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орж, соёрхон баталснаар хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, төрийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалахад хүлээх үүрэг тодорхой болсон төдийгүй улмаар хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, гэр бүл, нийгмийн амьдралд оролцох эрхийг бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай болсон.

Монгол Улсын Үндсэн хууль болон УИХ-аас 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1999 онд Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомж батлагдсанаар хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдсэн билээ. Мөн хүүхдийн эрхтэй холбоотой хэд хэдэн гэрээ конвенцид нэгдэн

орж, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүүхдийн эрх хамгаалагдах боломжтой болсон юм. Гэсэн хэдий ч манай улс орны эдийн засаг, улс төрийн үйл явцаас шалтгаалан хүүхдийн ашиг, сонирхол, эрхийн хамгааллын өргөн хүрээтэй энэ асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд хүндрэлтэй олон асуудал байна.

Тэдгээрийн нэгээхэн чухал хэсэг нь гэр бүлийн хүрээнд хүүхдийн ашиг, сонирхол, эрхийн хамгаалалтын асуудлыг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж шийдвэрлэх асуудал юм. Энэ сэдвийг хөндөхийн тулд эхлээд хүүхдийн ашиг, сонирхол эрхийн хамгаалал гэдэг ойлголтыг гэр бүлийн эрх зүйн хүрээнд хэрхэн авч үзэх талаар тодруулах нь зүйтэй гэж үзлээ.

Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д нэр бүлийн гишүүн гэж тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садан хүнийг хэлнэ, мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилтыг тодорхойлохдоо “ гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна” хэмээн тодорхойлсон нь энэ хуулиар хүүхэдтэй холбогдсон харилцааг гэр бүлийн гишүүний хувьд эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах үндэслэлтэй байна. Иймд хүүхдийн тэжээн тэтгүүлэх, асран хамгаалуулах эрхийн хүрээн дэхь асуудлыг тусгайлан авч үзээд энэ талаарх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар өөрийн санал хэлэлцүүлэхийг хүсэж байна.

Гадаадын ихэнх улс оронд хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг үндсэн 2 аргаар тодорхойлдог байна.

1. Тэжээгчийн сар бүрийн цалин, түүнтэй адилтгах орлогоос хүүхэд тус бүрд тодорхой хувиар.
2. Хүүхэд тус бүрийн хэрэглээг харгалзан сар бүр тэтгэлэгийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэн тогтоодог.

Манай улсад өмнө үйлчилж байсан 1973 оны Гэр бүлийн хуульд дээр дурьдсан нэгдүгээр аргын үндсэн дээр буюу тэжээгчийн сар бүрийн цалингаас нэг хүүхдэд 15-25 хувь, хоёр хүүхдэд 35 хувь хүртэл, Гурав ба түүнээс дээш хүүхдэд 50 хувь хүртэл хэмжээгээр тогтоодог байжээ. Харин манай улс зах зээлийн харилцаанд шилжсэнтэй уялдан ажилгүйдэл нэлээд их хувийг эзлэх болсон учраас тэтгэлэг төлөгч ажилгүй цалин орлоггүй болсон гэх үндэслэлээр хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй, хүүхдийн эрх ашиг зөрчигдөх болсон юм.

Тийм учраас УИХ-аас 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг батлахдаа хүүхэд тус бүрт тухайн нутаг дэвсгэрт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр буюу тодорхой мөнгөн дүнг тогтоож өгдөг болсон байна.

Тэжээгч нь хүүхдийн тэтгэлэгийг сар бүр төлөх үүрэгтэй бөгөөд цалин орлогогүй, санхүүгийн боломжгүй зэрэг шалтгаанаар хүүхдийг тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөх үндэслэлгүй юм.

Харин тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадвараа алдсан, тэтгэлэг авагчаас бага орлоготой нь тогтоогдвол тэтгэлэгийн хэмжээг багасгах асуудлыг шүүх шийдвэрлэх боломжтой.

Гэр бүлийн тухай хууль дахь хүүхдийн тэтгэлгийн эрх зүн зохицуулалтыг дээр дурьдсанаас дүгнэн үзэхэд:

1. Тэтгэлэгт хамрагдах хүүхдийг 16 настай | суралцаж байгаа бол 18 нас \ болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй байхаар тогтоосон явдал нь гэр бүлийн тухай хуулийн зарим заалтууд агуулгаараа хоорондоо зөрчилдөж байна.

Тухайлбал: Гэр бүлийн тухай хуулийн 38-р зүйлийн 38.1-д эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй гэсэн заалт байдаг талаар дурьдсан. Энэ нь хүүхдийг тэжээн тэтгэхэд заавал байх нэг гол шалгуур бол нас юм гэдгийг илэрхийлсэн төдийгүй эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх хүүхэд насанд хүрээгүй байна гэдгийг тодорхой болгож байгаа юм.

Тэгвэл насанд хүрээгүй гэж хэнийг ойлгох вэ гэдгийг тодруулхад Иргэний хуулийн 16 дугаар зүйлд зааснаар 14-18 хүртэлх насны хүмүүсийг түүнд багтааж, харин мөн хуулийн 15 дугаар зүйлд 18 насанд хүрснээр өөрийн хийж буй үйлдлийнхээ учир холбогдлыг бүрэн ойлгож, түүнээс гарах үр дагаврыг өөрөө хариуцах боломжтой болж байна.

Гэтэл Гэр бүлийн тухай хуульд хэрэв хүүхэд суралцаж байгаа бол 18 настай болтол нь, бусад тохиолдолд 16 настай хүүхдэд хуульд заасан хэмжээний тэтгэлэг тогтоохоор заасан нь насанд хүрээгүй тэтгэлэг авагчийн эрх ашгийг хохироосон учир дутагдалтай зохицуулалт болж байна. Тийм учраас хүүхдийг нийтэд нь 18 насанд хүртэл тэжээн тэтгэдэг хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хүүхдийн тэтгэлэгийн хэмжээ хүүхдийн амьдарч байгаа бүс нутаг, насны байдлаас шалтгаалан сард дунджаар 70000 төгрөг байгаа нь өнөөгийн нөхцөлд хүүхдийн хэрэгцээг хангаж чадахгүй, үүнээс улбаалан хүүхэд ихээхэн хохирч байгаа тул хуулиар тогтоох тэтгэлэгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Хүүхдийн тэтгэлэгийг тогтоохдоо хүүхдийн амьжиргааны түвшин, хэрэгцээ, тэжээгчийн хөрөнгө, цалин орлоготой уялдуулан зохицуулдаг болгох. Нэгэнт хүүхдийн тэтгэлэгийн хэмжээ хүрэлцэхгүй байгаа тул хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг нотлох баримтыг үндэслэн нэмэгдүүлэн тогтоох нь зүйтэй санагддаг.

Хүүхдэд онцгой нөхцөл байдал тохиолдсон үед нэмэлт зардал гаргуулах тухай хуульд тусгасан хэдий ч зөвхөн тодорхой хэдэн тохиолдолын хүрээнд л хязгаарлажээ.

Нэгэнт хүүхдийн тэтгэлгийг багасгаж болохоор зааж өгсөн байх тул тэтгэлэг төлөгч хүүхдийн тэтгэлэгийг нэмүү байдлаар төлөх бололцоотой бол хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хүүхдэд нэмэгдэл тэтгэлэг гаргуулах нь зүйтэй.

Хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай

Хүүхдийг тэжээн тэтгэх нь эцэг, эхийн хувьд үүрэг байдаг учраас энэхүү үүргээ эс биелүүлвэл хариуцлага тооцох үр дагавар үүсэх учиртай.

Хүүхдээ тэжээн тэтгэх үүргийг биелүүлээгүй. санаатай зайлсхийсэн эцэг, эхэд хариуцлага тооцох асуудал нь гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын чухал

асуудал юм. Учир нь гэр бүлийн эрх зүйн хамгаалалт нь гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах зорилгыг агуулж байх бөгөөд эрх нь зөрчигдсөн этгээд өөрийн эрхээ хамгаалахын тулд хуульд заасан аргуудыг ашиглан хэрэгжүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл эцэг, эх нь хүүхдээ тэтгэхээс зайлсхийвэл хүүхдийн эрх, ашиг, сонирхол зөрчигдөж, хүүхдийн амьдрах нөхцөл дордож, улмаар эрүүл мэнд өсч бойжих, оюун ухаан, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох эрх нь ноцтой зөрчигдөнө.

Тийм учраас хүүхдийн хамгаалагдаж буй эрхийн онцлог, эцэг, эхийн гэм буруугийн шинж байдлаас шалтгаалан хүүхдийн эрхийг хамгаалах аргыг сонгох буюу хариуцлагын шинжтэй аргуудыг ашиглана.

Гэр бүлийн тухай хуулийн 50 дугаар зүйлд зааснаар тэтгэлэг төлөх тухай талууд гэрээ байгуулсан бөгөөд тэтгэлэгийг хугацаанд нь төлөөгүй бол учирсан хохиролыг гэрээнд заасан журмаар нөхөн төлнө.

Мөн түүнчлэн шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлэгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлэгийн үнийн дүнгийн 0.5 хувийн алданги тооцно. Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлэгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна. Тэтгэлэгийг хугацаанд нь төлөөгүй улмаас учирсан хохиролыг нөхөн төлөх талаар гэрээнд заагаагүй бол алданги гаргуулах талаар заасан. Өөрөөр хэлбэл гэр бүлийн хуулийн зохицуулалтаас хархад тэтгэгч тэтгэлэгийг хугацаандаа төлөхгүй бол учирсан хохиролыг нөхөн төлүүлэх,

хожимдуулсан хоног тутамд алданги төлүүлэхээр заажээ.

Харин практикт тэтгэлэг төлөхгүй байгаа тэжээгчээс алданги, хохиролыг гаргуулах тухай хуулийн энэхүү зохицуулалт хэрэгждэггүй.

Алдангийг тогтоож байгаа нь тэтгэлэг төлөгчийг хугацаандаа хүүхдийнхээ тэтгэлэгийг төлөөгүй тохиолдолд түүнд оногдуулж байгаа нэмэгдэл үүрэг буюу хариуцлагын нэг арга. Харин ямар журмаар алдангийг гаргуулах вэ гэдэг нарийвчилсан зохицуулалт байхгүй.

Энэ тохиололд алданги төлүүлэх талаар шүүхийн шийдвэр заавал байх эсэх, эсхүл шийдвэр гүйцэтгэгч дангаараа алданги гаргуулах хариуцлагыг төлбөр төлөгчид ногдуулах эрхтэй эсэх асуудал энд гарч ирдэг.

Гэр бүлийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд тэтгэлэг төлөгчийн мөнгөн хадгаламж болон бусад эд хөрөнгөнөөс тэтгэлэг гаргуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмыг баримтална гэжээ.

Энэхүү зохицуулалтыг удирдлага болгон тэтгэлэг төлөгчийн тэтгэлэгийг шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан журмыг баримтлан гаргуулах үндэслэлтэй.

Шийдвэр гүйцэтгэгч нь дор дурьдсан 2 үндэслэл байвал хүүхдийн тэтгэлэгийг гаргуулна. Үүнд:

1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүгчийн захирамж гарч, гүйцэтгэх хуудас

бичигдсэн тохиолдолд хүүхдийн тэтгэлэгийг гаргуулах ажиллагаа явуулна.

2. Тэжээн тэтгэх гэрээндээ тэжээгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнийг үл маргах журмаар биелүүлэх талаар тохиролцож нотариатаар гэрээгээ гэрчлүүлсэн бол нотариатын мэдэгдэх хуудсыг бичүүлсний үндсэн дээр гэрээний үүргийг биелүүлэхийг шаардах эрхтэй.

Шүүх ИХШХШТХуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-т зааснаар нотариатын мэдэгдэх хуудсыг биелүүлэх боломжийг хянан үзэж мэдэгдэх хуудсыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор шүүгч түүнийг албадан биелүүлэх тухай захирамж гаргаж, гүйцэтгэх хуудас бичиж, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэх ба энэ тохиололд Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэгч гаргуулна.

Харин шийдвэр гүйцэтгэгч нь алдангийн хариуцлага тооцох тухайд шүүхийн шийдвэрт заагаагүй, үнийн дүн нь тодорхой бус тул тэтгэлэг төлөгчөөс албадан гаргуулах шаардлага бий болж байгаа юм.

Хүүхдийн тэтгэлэг төлөх нь маргаангүй байгаа, шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудсанд тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөх үүрэгтэй болох нь нэгэнт тогтоогдсон, алдангийн хэмжээ, хязгаарыг хуульд нарийвчлан заасан зэрэг нь шүүхийн нэмэлт шийдвэр гаргахгүйгээр шийдвэр гүйцэтгэгч бие даан шаардах эрхтэй мэт.

Гэтэл энэ нь ШШГТухай хуулийн 4, 10 дугар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэни хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, бусад байгууллагын шүүх баталгаажуулсан шийдвэр байх,

шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглосон заалттай зөрчилдөж байгаа юм.

Гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчөөс төлбөр авагчид олговол зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, шүүхээс баталгаажуулсан мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас зэрэг багтаж байхаар хуульчилсан байхад шүүхийн шийдвэрт заагдаагүй алдангийг шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулах боломжгүй учраас алданги гаргуулах хуулийн заалт амьдралд хэрэгжихгүй байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь төлбөр гаргуулах бусад ажиллагаанаас дараах онцлогтой байдаг.

1. Хүүхдийн тэтгэлэг нь сар бүр тодорхой мөнгөн дүнгээр буюу төлбөр төлөгчийн цалингаас суутгах тогтмол төлөгдөх төлбөрт хамаарч байдаг.
2. Хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн насны байдлаас хамааран өөрчлөгддөг.
3. Хүүхдийн тэтгэлэгийг шүүхээс тогтоосон бол жил бүрийн амьжиргааны түвшинээс хамааран өөрчлөгдөж байдаг.
4. Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс өөр төлбөрийг суутгахыг хориглодог.
5. Хүүхдийн тэтгэлэг бусад бүх төлбөрөөс тэргүүн ээлжинд төлөгддөг.
6. Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс урамшуулал тооцохыг хориглодог.
7. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хүүхдийг 18 нас

хүртэл хугацааны тэтгэлэгийг бүрэн төлж дуусах хүртэл үргэлжилнэ.

Өөрөөр хэлбэл хүүхэд 18 насанд хүрсэн ч тэтгэлэг төлөгч нь тэтгэлэгээ бүрэн төлөөгүй тохиолдолд тэтгэлэг гаргуулах ажиллагаа үргэлжлэн явагддаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүүхдийн тэтгэлэгийг гаргуулахдаа Гэр бүлийн тухай хууль, ШШГТХуулийг удирдлага болгох бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 51 р зүйлийн 51.1 д тэтгэлэг төлөгчийн мөнгөн хадгамжийн болон бусад эд хөрөнгөнөөс тэтгэлэг гаргуулахдаа ШШГТХуульд заасан журмыг баримтална.

ШШГТХуулийн 66 дугаар зүйлийн 66.1 д хүүхдийн тэтгэлэг гаргуулах журмыг гэр бүлийн тухай хуулиар тогтооно гэсэн заалтуудыг тодорхой болгон аль хуульд хүүхдийн тэтгэлэг төлүүлэх журмыг тогтооход нэг мөр зааж зохицуулах хуулийн дагуу хүүхдийн тэтгэлэг биелдэг эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа вм.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжийн зохицуулалтийн хүрээнд хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тэтгэлэг төлөгчид захиргааны болон эрүүгийн хариуцлага тооцох үндэслэлтэй.

Захиргааны хариуцлагыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам зөрчсөн тэтгэлэг төлөгч болон журам зөрчсөн бусад этгээдэд ногдуулж болно.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн иргэнээс төлбөл зохих тэтгэлэгийг төлүүлж түүнийг 50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах шийтгэлийг сум

дүүргийн Засаг даргын шийдвэрээр Захиргааны шийтгэл ногдуулах зохицуулалттай боловч энэ шийтгэлийг ногдуулах сум дүүргийн харьяалал нь тодорхой бус байдаг. Мөн Эрүүгийн хуулийн 120 дугаар зүйлд зааснаар Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Хүүхдээ тэжээн тэтгэхээс зайлсхийсэн тохиолдолд хүлээлгэн хариуцлагын талаар дээр нэрлэсэн хуулиудад тодорхой заасан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм.

Цаашид хүүхдийг тэжээн тэтгүүлэх эрхийг зохих хэмжэээнд хангах үүднээс энэ талаар хуулийг боловсронгуй болгох талаар :

1. Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд хүүхдийг 18 настай болтол нь тэтгэлэг тогтоож байхаар өөрчлөлт оруулах
2. Хүүхдийн хэрэгцээ амжиргааны түвшин тэтгэлэг төлөгчийн цалин орлоготой нь уялдуулан тэтгэлэгийн хэмжээг тогтоодог журамд шилжих
3. Нэгэнт хуулиар тогтоосон тэтгэлгийн хэмжээ бага учраас аль болох тохиролцон гэрээний үндсэн дээр төлөх боломжийг эцэг эхэд олгох
4. Эцэг эх нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс санаатай зайлсхийдэг, хугацаа хождог үүнээс үүдэн хүүхдийн эрх ашиг хохироход хүрдэг. Имйд шүүх шийдвэр гаргахдаа хүүхдийн тэтгэлгийг нөхөн гаргуулдаг зохицуулалт шаардлагатай байна. Одоо мөрдөгдөж байгаа гэр бүлийн тухай хуульд шүүх тэтгэлгийг нөхөн гаргуулах тухай заалт байгаа боловч ямар нөхцөлд хэдийд буюу шүүхэд хандахаас өмнөх үеийн эсвэл

шүүхийн шийдвэр гарсаны дараа тэтгэлэг төлхөөс зайлсхийсэн үеийн гэх нь тодорхойгүй байна.

5. Хүүхдийн тэтгэлэгийг төлөхөөс санаатай зайлсхийсэн тэтгэлэг төлөгчид хүлээлгэх иргэний хариуцлага хэрэгжих эрх зүйн орчинг бүрдүүлэх, эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангатах. Тухайн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг нарийн тогтоож өгөх.
6. Гэр бүлийн тухай хуулийн 51, ШШГТХ ийн 66.1 заалтуудыг тодорхой болгон аль хуульд хүүхдийн тэтгэлэг төлүүлэх журмыг тогтоохийг нэг мөр зааж зохицуулах. Хуулийн дагуу хүүхдийн тэтгэлэг биелдэг эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
7. ШШГА ны явцад хүүхдийн тэтгэлэг гаргуулах бие даасан төрөлжсөн албатай болох, ШГ ч энэхүү онцлог ажиллагааг гүйцэтгэх талаар мэрэгшсэн байх зохицуулалтийг ШШГТХуульд тусгаж өгөх зэрэг асуудалыг дэвшүүлж байна.